



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

Боловсрол
судлал

БОЛОВСРОЛ СУДЛАЛ

Энэхүү дугаарыг Боловсрол, сэтгэл судлалын
тэнхимээс эрхлэн гаргав.

ISSN-1818-8478

2022 Дугаар 22 (567)

ГАРЧИГ

БОЛОВСРОЛ СУДЛАЛ

Aimin, M.Дэлгэржав

Өөр өөр чадвартай хос хэлтэй сурагчдын, бие даасан хяналттай чиг үүрэг холбогдох судалгааны үр дүн 6

Wurichahu, M.Дэлгэржав

Монголын болон өвөр монголын дунд ангийн сурагчдын эцэг эхийн хандлагыг судалсан үр дүн 10

Б.Ариунтуул, Я.Бадамсүрэн

Академик англи хэлний дунд түвшний хичээлд шинэ үгс цээжлүүлэх, хэрэглээнд оруулах дадлага хичээлд ой тогтоолтын зарим түгээмэл аргыг ашиглах нь 16

Д.Болормаа, Д.Бадамханд

Англи хэл-6 сурах бичгийн дасгал даалгавруудыг Блумын таксономийн түвшингээр судлах нь. 22

Н.Буянхишиг, Ж.Даваа

“Барилгын засал-чимэглэлчин” мэргэжлээр суралцагчдад ур чадвар эзэмшүүлэхэд нөлөөлөх хүчин зүйлсийг судалсан үр дүн..... 26

Р.Дарьхүү

“Монгол ёс, хүмүүжил” болон “иргэний ёс зүйн боловсрол” сурах бичгийн агуулга, арга зүйд хийсэн шинжилгээ..... 31

Ч.Должинсүрэн, Г.Пүрэвчулуун, Б.Солонго, Ш.Ариунбаяр, Н.Ууганцэцэг, Г.Болорчимэг

Орон нутагт ажиллаж байгаа физик математикийн багш нарын мэргэжлийн хөгжлийн хэрэгцээ шаардлага 39

Х.Нансалмаа, М.Сугармаа

Эрүүл мэндийн нийгмийн ажил мэргэжлийн бакалаврын сургалтын дадлага ажилд хийсэн өөрийн үнэлгээ 45

Ц.Отгонмягмар, Ж.Сүхбаатар

Мэргэжлийн боловсрол, сургалтын хөтөлбөр, хувьсах зардлын шинжилгээний зарим үр дүн 49

О.Сайнзаяа, Ж.Даваа

Ээлжит хичээлийн төлөвлөлтийн судалгаа 57

Б.Сайханбаяр, А.Санжмятав

Багшийн хөгжилд нөлөөлөх зарим хүчин зүйлсийг тодруулах нь (Их дээд сургуулийн жишээн дээр) 66

Г.Уянга, И.Лхам

Нийгмийн чухал институт болох сургуулийн талаарх Ж.Дьюнгийн үзэл баримтлал 76

Б.Хулан, М.Нарантуяа

Анагаах ухааны сургуулийн номын сангаар үйлчлүүлж байгаа оюутнуудын сэтгэл ханамж ба номын хүрэлцээнд хийсэн судалгаа..... 83

Ш.Цэрэндулам, Д.Чимгээ, А.Болор

“Бизнес хүний эрх”-ийн боловсрол бизнесийн сургуулийн үүрэг, оролцоо..... 87

Н.Чанцалдулам, Д.Эрдэнэбаатар

ЕБС-ийн физикийн цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тулгарч буй асуудал..... 100

Д.Эрдмаа, М.Дэлгэржав

Музейн боловсролын ажилтны хөгжлийн зарим асуудал..... 105

Г.Эрдэнэбаяр, Д.Оюунгэрэл

Боловсролын зорилгын тухай зарим философичийн үзэл санаа..... 112

ЭРҮҮЛ МЭНДИЙН НИЙГМИЙН АЖИЛ МЭРГЭЖЛИЙН БАКАЛАВРЫН СУРГАЛТЫН ДАДЛАГА АЖИЛД ХИЙСЭН ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭ

Х.Нансалмаа, MPh
Г.Золжаргалан, MSW
М.Сугармаа, Ph.D, дэд профессор
(АШУҮИС-ийн НЭМС, ЭМНАНУТ)

Товч агуулга: Нийгмийн ажил нь практикт суурилсан мэргэжил болохын хувьд дадлага ажил нь нийгмийн ажлын мэргэжилтэн бэлтгэх боловсролын хөтөлбөрийн үндсэн хэсэг байдаг. Эрүүл мэндийн нийгмийн ажилтны оюутнууд бакалаврын хөтөлбөрт суралцах хугацаандаа 3 удаагийн 10 кр бүхий 480 цагийн дадлагыг гүйцэтгэдэг. Бид бакалаврын сургалтын дадлагын хичээлийг үнэлэх замаар цаашид дадлага ажлыг сайжруулах хэрэгцээг тодорхойлох зорилгоор энэхүү өөрийн үнэлгээний судалгааг хийлээ.

Үнэлгээнд 2020-2021 хичээлийн жилийн зуны дадлага, 2021-2022 хичээлийн жилийн намрын дадлагын удирдамжууд, тайлан хамгаалалтын хурлын протоколууд болон оюутныг үнэлсэн дадлага удирдагчийн үнэлгээнд шинжилгээ хийсэн. Мөн тухайн дадлага ажлыг гүйцэтгэсэн Эрүүл мэндийн нийгмийн ажлын ангийн 2-4 дүгээр дамжааны 52 оюутны дадлагын өөрийн үнэлгээг шинжилж боловсруулалт хийлээ.

АШУҮИС-ийн Эрүүл мэндийн нийгмийн ажил, нийгмийн ухааны тэнхим нь оюутнуудын дадлага ажлыг зохион байгуулах, үнэлэх ажлыг бие даан гүйцэтгэж, дадлагын төрөл тус бүрд зориулсан удирдамжийг боловсруулж, оюутнуудын эзэмшсэн мэдлэг, ур чадварыг үнэлэхдээ дадлага тус бүрд ялгаатай аргуудыг ашиглаж байна. Дадлага удирдагч болон оюутны өөрийн үнэлгээгээр Эрүүл мэндийн нийгмийн ажил мэргэжлийн дадлага ажлууд хангалттай сайн байна. Байгууллагын дадлага удирдагчийн үнэлгээ дадлагын төрлийн хувьд ялгаатай ($p < 0.05$) бол оюутны өөрийн үнэлгээ дадлагын төрлөөр ялгаагүй байна. Дадлага ажлыг цаашид сайжруулахын тулд онолын мэдлэгийг практик ашиглахад дэмжих, дадлагын зохион байгуулалтад, цаг хугацааг анхаарах хэрэгтэй байна.

Түлхүүр үг: Эрүүл мэнд, Нийгмийн ажил, Дадлага, Үнэлгээ

Оршил: Олон улсын нийгмийн ажлын холбооны тодорхойлсноор нийгмийн ажил нь

практикт тулгуурласан мэргэжил бөгөөд нийгмийн өөрчлөлт, хөгжил, мөн хүмүүсийн эрхмэдэл, эрх чөлөөг дэмждэг шинжлэх ухааны нэг салбар юм (International Federation of Social Workers, 2022). Практикт тулгуурласан мэргэжил болохын хувьд оюутны дадлага нь нийгмийн ажлын мэргэжилтэн бэлтгэх боловсролын хөтөлбөрийн үндсэн хэсэг болдог. Учир нь оюутан дадлагын явцад өөрийн мэдлэг, ур чадвар, ёс зүйн зарчмуудыг ашиглах, хөгжүүлэн төлөвшүүлэх боломжтой байдаг (Нямдорж.М, 2018). 2009 онд батлагдсан Нийгмийн ажил мэргэжлийн дээд боловсролын стандартад бакалаврын сургалтын дадлагын нийт багтаамжийг 12-оос багагүй долоо хоног байхаар тусгасан

(Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төв, 2009).

Эрүүл мэндийн нийгмийн ажил мэргэжлээр 2003 оноос эхлэн Анагаахын шинжлэх ухааны үндсэний их сургуульд 4 жилийн хугацаатайгаар мэргэжилтэн бэлтгэж байна. Сургалтын хөтөлбөрийн дагуу 3 удаагийн 10 кр бүхий 480 цагийн дадлагыг оюутнууд гүйцэтгэдэг. Оюутнууд 2-р дамжаанд Өрхийн эрүүл мэндийн төв дээр танилцах дадлага, 3-р дамжаанд Аймаг, дүүргийн эмнэлэг болон нийгмийн үйлчилгээний байгууллага дээр үйлдвэрлэлийн дадлага, 4-р дамжаанд Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдэд мэргэшүүлэх дадлага хийж байна.

Бид бакалаврын сургалтын дадлагын

хичээлийг үнэлэх замаар цаашид дадлага ажлыг сайжруулах хэрэгцээг тодорхойлох зорилгоор энэхүү судалгааг хийлээ.

Судалгааны арга, боловсруулалт. Үнэлгээнд 2020-2021 хичээлийн жилийн зуны дадлага, 2021-2022 хичээлийн жилийн намрын дадлагын удирдамжууд, тайлан хамгаалалтын хурлын протоколууд, оюутныг үнэлсэн дадлага удирдагчийн үнэлгээнд шинжилгээ хийсэн. Мөн тухайн дадлага ажлуудыг гүйцэтгэсэн 2-4 дүгээр дамжааны 52 оюутны дадлагын өөрийн үнэлгээг шинжилсэн. Оюутнууд дадлагын өөрийн үнэлгээг 5 шалгуураар, дадлага удирдагч багш болон байгууллагын дадлагын удирдагчийг 6 шалгуур үзүүлэлтээр үнэлдэг. Мөн дадлага удирдагч оюутныг 6 шалгуур үзүүлэлтээр үнэлдэг. Үнэлгээний шалгуур тус бүр дээр 1-5 оноо өгдөг бөгөөд 5 оноо нь маш сайныг илэрхийлж байгаа бол 1 оноо нь маш муу оноог илэрхийлнэ. Тоон судалгааны мэдээллийг SPSS 23.0 програм ашиглан боловсруулсан. Чанарын буюу баримтын мэдээлэлд агуулгын шинжилгээ хийв.

Үндсэн хэсэг: Дадлага ажлын ерөнхий зохион байгуулалт:


АШУҮИС-ийн Эрүүл мэндийн нийгмийн ажил, нийгмийн ухааны тэнхим нь ЭМНА-ын оюутнуудын танилцах, үйлдвэрлэлийн, мэргэшүүлэх гэсэн гурван төрлийн дадлага ажлыг зохион байгуулах, үнэлэх ажлыг бие даан гүйцэтгэдэг. Дадлагын төрөл тус бүрд зориулсан удирдамжийг боловсруулж, Төгсөлтийн өмнөх сургалтын бодлого

зохицуулалтын газар болон бүрэлдэхүүн сургуулийн захирлаар батлуулаг. Удирдамжийн дагуу дадлага хийх боломжтой байгууллагуудтай холбогдон албан хүсэлт илгээх, дадлага удирдагчдад нэгдсэн болон тусгайлан мэдээлэл өгөх үйл ажиллагааг дадлагын өмнө зохион байгуулдаг.

Дадлага ажил дууссаны дараа оюутнуудын эзэмшсэн мэдлэг, ур чадварыг үнэлэхдээ дадлага тус бүрт ялгаатай аргуудыг ашиглаж байна. Тухайлбал, танилцах дадлагын тайлан хамгаалалтыг илтгэл хэлэлцүүлэх, үйлдвэрлэлийн дадлагын тайланг багаар ханан илтгэл танилцуулах, харин мэргэшүүлэх дадлагыг оюутан тус бүр кейс файл бүхий тайлан илгээх хэлбэрээр тус тус хамгаалуулдаг. Дадлагын тайлангийн үнэлгээг нийгмийн ажлын багш нарын оролцоотойгоор буюу багийн хэлбэрээр зохион байгуулж байна.

Дадлагын үнэлгээний үр дүн: Дадлагын үнэлгээний 40.4 хувийг мэргэшүүлэх дадлага, 26.9 хувийг үйлдвэрлэлийн дадлага, 32.7 хувийг танилцах дадлага эзэлж байна. Дадлагын ерөнхий үнэлгээ 10 онооноос 8.63 ± 1.74 , оюутны өөрийн үнэлгээ 25 онооноос 22 ± 2.7 , удирдагч багш болон байгууллагын дадлага удирдагч багшид өгсөн үнэлгээ 30 оноос 27.67 ± 3.23 , байгууллагын дадлага удирдагч оюутанд өгсөн үнэлгээ 30 онооноос 27.9 ± 2.9 өгсөн байна.

График 1: Дадлага ажлын үнэлгээ



Удирдагч багшид өгсөн үнэлгээ, удирдагч багшаас оюутанд өгсөн үнэлгээ нь дадлагын төрлийн хувьд ялгаатай буюу үйлдвэрлэлийн дадлагын үед дадлага удирдагч багшид өгсөн үнэлгээ өндөр, мэргэшүүлэх дадлагын үед

байгууллагын дадлага удирдагчаас оюутанд өгсөн үнэлгээ өндөр байна ($p < 0.05$). Дадлагын ерөнхий үнэлгээ, оюутны өөрийн үнэлгээг дадлагын төрөлтэй харьцуулан судлахад ялгаа байхгүй байна.

Хүснэгт 1. Оюутны өөрийн үнэлгээ

№	Өөрийн үнэлгээ	Дундаж оноо
1	Оюутны хувьд мэргэжлийн итгэл үнэмшил, мэргэжлийн төлөвшилт нэмэгдсэн	4.50
2	Дадлагын хугацаанд мэргэжлийн үнэт зүйлс, ёс зүйн зарчмыг баримтлан ажилласан	4.46
3	Танхимын сургалтаар олж авсан мэдлэгээ ашигласан	4.19
4	Тухайн байгууллагын зүгээс үйлчилгээ үзүүлэхэд нийгмийн ажилтны гүйцэтгэх үүрэг хариуцлагыг тодорхойлсон	4.26
5	Цагийг үр бүтээлтэй ашиглаж, ажлаа зөв төлөвлөж зохион байгуулсан	4.60
Дундаж оноо		4.40

Оюутнуудын өөрийн үнэлгээнээс үзэхэд дадлагын хугацаанд цагийг үр бүтээлтэй ашиглаж, ажлаа зөв төлөвлөж зохион байгуулсан гэсэн шалгуур дээр хамгийн

өндөр үнэлгээ өгсөн бол танхимын сургалтаар олж авсан мэдлэгээ ашигласан байдал дээр хамгийн бага оноог өгсөн байна.

Хүснэгт 2. Дадлага удирдагчийг үнэлсэн үнэлгээ

№	Дадлага удирдагчийг үнэлсэн үнэлгээ	Дундаж оноо
1	Мэргэжлийн удирдлагаар хангах уулзалтын үед удирдагч багш асуусан асуулт, хэлэлцэх асуудалд мэргэжлийн төвшний зөвлөгөө өгч байсан.	4.60
2	Удирдагч багшийн зөвлөгөө суралцах төлөвлөгөө боловсруулахад тустай байсан	4.58
3	Удирдагч багш тусламж хэрэгтэй үед эргэх холбоо сайтай байсан.	4.64
4	Мэргэжлийн удирдлагаар хангах уулзалтын үед байгууллагын удирдагч асуусан асуулт, хэлэлцэх асуудалд мэргэжлийн төвшний зөвлөгөө өгч байсан	4.50
5	Байгууллагын удирдагч багшийн зөвлөгөө суралцах төлөвлөгөө боловсруулахад тустай байсан.	4.66
6	Байгууллагын удирдагч тусламж хэрэгтэй үед эргэх холбоо сайтай байсан.	4.63
Дундаж оноо		4.60

Оюутнаас дадлага удирдагчийг үнэлсэн үнэлгээний хувьд суралцах төлөвлөгөө боловсруулахад байгууллагын дадлага удирдагчийн зөвлөгөө тустай байсан гэсэн шалгуур дээр оюутнууд хамгийн өндөр үнэлгээг өгсөн байна. Удирдамжид тусгасны дагуу байгууллагын дадлага удирдагч суралцах төлөвлөгөөг хянах, гарын үсэг

зурж, баталгаажуулах үүрэгтэй байдаг нь хариуцлагыг нэмэгдүүлэхэд нөлөөлдөг байх боломжтой юм. Энэ бүлэгт хамгийн бага үнэлгээг байгууллагын дадлага удирдагч мэргэжлийн удирдлагаар хангах, асуусан асуултад хариулах, хэлэлцэх асуудалд мэргэжлийн төвшний үнэлгээ өгч байсан гэсэн үзүүлэлтүүдэд өгсөн байна.

Хүснэгт 3. Байгууллагын дадлага удирдагчаас оюутныг үнэлсэн үнэлгээ

№	Оюутныг үнэлсэн үнэлгээ	Дундаж оноо
1	Танхимд үзсэн мэдлэгээ практик үйл ажиллагаанд ашигласан байдал	4.62
2	Байгууллагын дотоод дүрэм журмыг мөрдөж ажилласан байдал	4.91
3	Харилцааны болон ёс зүйн зөрчилгүй ажилласан байдал	4.85
4	Байгууллагын тусламж үйлчилгээнд зайлшгүй шаардлагатай үйлчилгээ, үнэлгээний маягт боловсруулсан эсэх	4.50
5	Хувь хүн, гэр бүл, бүлэгтэй ажиллах мэргэжлийн практик ур чадвараа хөгжүүлсэн байдал	4.47
6	Оюутны ирцийн байдал	4.70
Дундаж оноо		4.67

Байгууллагын дадлага удирдагчаас байгууллагын дотоод дүрэм журмыг мөрдөж ажилласан байдал дээр оюутнуудад хамгийн өндөр оноог өгсөн байна. Харин мэргэжлийн практик ур чадвараа хөгжүүлсэн байдал дээр

хамгийн бага оноог өгсөн байна.

Эдгээр үнэлгээнүүдийг хооронд нь харьцуулах цаг байгаа юу? Багш х удирдагч, багш х оюутны үнэлгээ гэх мэтээр.

Хүснэгт 4. Дадлагын ерөнхий үнэлгээ

№	Ерөнхий үнэлгээ	Дундаж оноо
1	Дадлагын удирдамж болон холбогдох материалууд тустай байсан.	4.30
2	Дадлага ажлын зохион байгуулалт сайн байсан.	4.33
Дундаж оноо		4.31

Дадлагын тайлан хамгаалалтын явцаас харахад дадлага ажил нь байгууллагын албан хаагчдын зуны амралт (6-7 сар), байгууллагын жилийн тайлан (12-1 сар)-ийн үетэй давхцаж байгаа нь дадлагын зохион байгуулалттай холбоотой анхаарах асуудал байдаг байна. Тайлан хамгаалалтын хурлын тэмдэглэлүүдээс харахад дадлагын тайланг ялгаатай аргаар үнэлэх, үүнд багш нарын идэвхитэй оролцоог хангах нь оюутнуудад ажлын байрны дадлага туршлага болохоос гадна албан харилцаанд бэлтгэх суурь болж байна. Мөн дадлага бүрийн хүрээнд сайжруулах, анхаарах зүйлсийг багаар хэлэлцэх давуу талтай байна.

Энэхүү дадлага нь КОВИД-19 цар тахлын үед хийгдсэнээр онцлог байсан бөгөөд сургуулийн зүгээс дадлагын удирдамж бүрийг цар тахлын нөхцөл байдалтай уялдуулан боловсруулж, оюутны халдвар хамгаалал, эрсдэлийг давхар тооцон ажиллаж байсан. Өмнөх дадлагуудтай харьцуулбал даалгаврын бүтэц бага зэрэг өөрчлөгдсөн бөгөөд оюутнууд байгууллагын дадлага удирдагчаас илүү нарийн зааварчилгаа авч ажиллаж байсан.

Цаашид дадлага ажлын үнэлгээнд хийх судалгаа/үнэлгээг өргөжүүлж, хугацааг тогтмолжуулах шаардлагатай.

Дүгнэлт

Оюутан болон дадлага удирдагч нар АШУҮИС-ийн Эрүүл мэндийн нийгмийн ажил мэргэжлийн дадлага ажлуудыг хангалттай сайн гэж үнэлсэн байна. Дадлага ажлыг цаашид сайжруулахын тулд онолын мэдлэгийг практикт ашиглахад дэмжих, дадлагын зохион байгуулалтын хувьд дадлага хийх цаг хугацааг анхаарах хэрэгтэй байна.

Ном зүй

1. Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль, Нийгмийн эрүүл мэндийн сургууль, Эрүүл мэндийн нийгмийн ажил, нийгмийн ухааны тэнхим. (2021). *Танилцах дадлага ажлын удирдамж*
2. Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль, Нийгмийн эрүүл мэндийн сургууль, Эрүүл мэндийн нийгмийн ажил, нийгмийн ухааны тэнхим. (2021). *Үйлдвэрлэлийн дадлага ажлын удирдамж*
3. Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль, Нийгмийн эрүүл мэндийн сургууль, Эрүүл мэндийн нийгмийн ажил, нийгмийн ухааны тэнхим. (2021). *Мэргэшүүлэх дадлага ажлын удирдамж*
4. Нямдорж.М. (2018). *Нийгмийн ажлын дадлагын арга зүй*. Алмаз Пресс.
5. Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төв. (2009). *Нийгмийн ажил мэргэжлийн дээд боловсролын стандарт*. Улаанбаатар.
6. International Federation of Social Workers . (2022). Retrieved from <https://www.ifsw.org/what-is-social-work/global-definition-of-social-work/>
7. Judit Csoda, Andrea Diebel. World wide closed! Social worker field practice during the 'lockdown' period. *Social Work Education The International Journal*. (2020) VOL. 39, NO. 8, 1094–1106 <https://doi.org/10.1080/02615479.2020.1829580>